

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл: Автотээврийн тухай хуулийн 17¹ дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17^{1.3}, 17^{1.4} дахь заалтуудыг тус тус нэмсүгэй:

“17^{1.3}. Автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаарыг үнэ хаялцуулах дуудлага худалдаагаар борлуулж болно.

17^{1.4}. Автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаарын борлуулалтын орлогыг Хүүхдийн төлөө санд төвлөрүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.